

Төслийн товчоон

ШВЕЙЦАРИЙН ХӨГЖЛИЙН АГЕНТЛАГ



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарийн хөгжлийн агентлаг

2016 оны 1-р сар

Хэрэгжүүлэгч:



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН
ТАМГЫН ГАЗАР

ИРГЭДИЙН ОРОЛЦОО ТӨСӨЛ

БАРИМТ МЭДЭЭЛЭЛ

Хөтөлбөрийн нэр:

Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөр

Төслийн нэр:

Иргэдийн оролцоо төсөл

Хугацаа:

2015 – 2017

Төсөв:

500,000 шв.франк

Зорилтот бүлэг:

Монгол Улсын Засгийн газар
Нутгийн захиргааны байгууллагууд
Иргэний нийгмийн байгууллагууд
Иргэд

Зорилтот бүс нутаг:

Үндэсний хэмжээнд

Монгол Улсын төрөөс ардчиллыг бэхжүүлж, төвлөрлийг сааруулах нь үр дүнтэй, хүртээмжтэй хөгжилд хүрэх гол арга хэрэгсэл гэж үзэж байна. Энэ хүрээнд сайн засаглалын үндэс суурь болох шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэн, төвлөрлийг сааруулж, төрийн хариуцлагын тогтолцоог сайжруулахыг зорьж байна. Швейцарийн Холбооны Улс нь Иргэдийн оролцоо төслийн хүрээнд төрийн үйл хэрэг болон шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог хангах эрх зүйн орчныг бэхжүүлэхэд Монгол Улсад тууштай дэмжлэг үзүүлж байна.



Ховд аймгийн Нутгийн ордон дахь хэлэлцүүлэг: Иргэд орон нутгийн хөгжлийн асуудалд оролцож байна

ҮНДЭСЛЭЛ

Шууд ардчилал, иргэдийн оролцоо нь монголчуудын хувьд шинэ зүйл биш юм. 1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд "...ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөнхүү эрхээ сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаар уламжлан эдэлнэ"; 1995 оны Ард нийтийн санал асуулгын тухай хуульд шууд ардчиллын нэгэн хэрэгсэл болох эрх бүхий төрийн байгууллагаас санаачлах бүх нийтийн санал асуулгыг тусгасан байдаг. Ийнхүү хуулиар зохицуулсан хэдий ч иргэдийн оролцооны түвшин төдийлөн хангалтгүй хэвээр байв. Харин 2011 оноос шууд ардчилал, иргэдийн оролцоог бэхжүүлэхэд анхаарч, энэ санаачлагыг Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж манлайлж байна. Энэ хүрээнд Төсвийн тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Хууль тогтоомжийн тухай болон

Нийтийн сонсголын тухай хуулийг баталсан нь иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чухал ахиц дэвшил болж байна. Мөн иргэд хамтарч хэлэлцүүлэг хийх, хурал зөвлөгөөн зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлсэн иргэний танхимыг нийт аймаг, сумд, дүүргүүдэд байгуулаад байна. Иргэний оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой ахиц гарсан ч хуулийн хэрэгжилт хангалтгүй, хуулийн болон өөрсдийн эрхийн талаархи иргэдийн мэдлэг, мэдээлэл дутмаг байх зэрэг бэрхшээл байсаар байна. Мөн ард нийтийн санал асуулгыг санаачлах эрх зөвхөн Улсын Их Хурал, Засгийн газар, Ерөнхийлөгчид хуулиар олгогдсон байдаг. Иймээс иргэд тодорхой асуудал, шийдвэрийн талаар өөрсдөө санаачлан, бие даан шийдвэр гаргах эрхийг олгох бүх нийтийн санал асуулгын төрлийг нэвтрүүлэх нь чухал байгаа билээ.

ШХА-ийн зорилго:

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн эрх тэгш, тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахыг зорин.

ЗОРИЛГО

Орон нутгийн удирдлагаас иргэдийн өмнө тулгамдсан асуудал, хэрэгцээ, шаардлагад нийцсэн шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх

ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ХҮРЭХ ҮР ДҮН:

Хууль, эрх зүйн зохицуулалтын орчин: Төрийн байгууллагын шийдвэр, нутгийн удирдлагын үйл ажиллагаанд нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар иргэдийн оролцоог хангахад чиглэсэн хууль, эрх зүйн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэхээр ажиллах болно. Монгол Улсын Засгийн газар, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд зэрэг оролцогч талуудын хамтын ажиллагааг хангах замаар энэхүү зорилгод хүрнэ. Энэ зорилгын хүрээнд иргэд өөрсдөө санаачлах ард нийтийн санал асуулга, олон нийтийн хурал цуглаан, иргэний танхим, орон нутгийн асуудлаарх олон нийтийн хэлэлцүүлэг хийх, орон нутгийн удирдлагын санхүүгийн хариуцлага зэрэг иргэдийн оролцоог хангах гол асуудлыг авч үзнэ.

Олон нийттэй харилцах: Иргэдийг оролцох эрх болон энэ эрхээ хэрхэн хэрэгжүүлэх боломжийн талаарх болон бусад холбогдох асуудлаар мэдлэг,

“... Иргэдийн оролцоо, санаачилгыг дэмжнэ. Нэгэнт л тэр иргэдийн өөрсдийнх нь байгуулж байгаа, сайн сайхан явахын төлөө байгуулж байгаа нийгэм учраас тэдний оролцоог дэмждэг байх ёстой...”

*Монгол Улсын Ерөнхийлөгч
Ц.Элбэгдорж*



© Б. Ганзориг / Ерөнхийлөгчийн Тамгын газар

“Том төрөөс ухаалаг төр рүү” Үндэсний зөвлөлдөх уулзалт – Оролцогчид дэвшүүлсэн саналуудад санал өгч байгаа нь

мэдээллээр хангана. Ингэхдээ нийт иргэн болон нийгмийн тодорхой зорилтот бүлэг, тухайлбал өрх толгойлсон эмэгтэйчүүд, залуучууд, эмзэг бүлгийнхэн, алслагдмал нутгийн оршин суугчид зэрэг бүлэгт олон нийттэй харилцах стратегийг ашиглан мэдээллийг түгээнэ.

Үнэлгээ, харилцан суралцах: Иргэдийн оролцоог хангах үйл явцад тогтмол үнэлгээ, дүгнэлт хийснээр иргэдийн оролцооны бодлого, оролцооны арга замуудын үр нөлөөг тодорхойлж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг сайжруулан оновчтой болгох боломжийг бүрдүүлнэ. Орон нутаг, үндэсний болон олон улсын түвшин дэх сайн туршлагыг хуваалцана.

Олон улсын туршлага солилцоо: Монгол Улсын иргэдийн оролцооны талаар хуримтлуулсан мэдлэг, туршлагыг бусад улс оронтой хуваалцах, түгээн таниулах зорилгоор харилцан суралцах арга хэмжээг зохион байгуулна.



© Б. Ганзориг / Ерөнхийлөгчийн Тамгын газар

Иргэний боловсролын төвөөс Иргэний танхим зохион байгуулсан “Би иргэн” хэлэлцүүлэг – Ахлах ангийн сурагчид саналаа илэрхийлж байгаа нь

Хамтран хэрэгжүүлэгч түншүүд:

- Швейцарь Улсын Ардчилал судлалын төв

Холбоо барих: Иргэдийн оролцоо төсөл

Их эзэн Чингис хааны талбай-1
Төрийн ордон, 465 өрөө
Улаанбаатар, 14201
Монгол Улс

Утас: (976-51) 266 876
Цахим шуудан: sunjid@president.mn

Засаглалыг дэмжих, төвлөрлийг сааруулах хөтөлбөр

Скай плаза бизнес төв,
Олимпын гудамж 12,
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
Улаанбаатар хот

Утас: +976 11328848
Факс: +976 11331420
И-мэйл: ulaanbaatar@gdp.mn

Монгол дахь Швейцарийн ЭСЯ-ны Хамтын ажиллагааны газар

Скай Плаза Бизнес төв,
Олимпын гудамж 12,
Сүхбаатар дүүрэг, 1 дүгээр хороо,
Улаанбаатар хот

Ш/Х 37, Улаанбаатар 14210,
Монгол улс

Утас: +976 11 331 422
Факс: +976 11 331 420
И-мэйл: ulaanbaatar@eda.admin.ch
Вэб хуудас: www.swiss-cooperation.admin.ch/mongolia